

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04-р сарын 30-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

“Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иас тус тус баталсан холбогдох журмууд болон “Сүү” ХК-ийн Дүрмийг тус тус удирдлага болгон, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 04 сарын 23-ны өдрийн 104 тоот тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан компанийн албан ёсны <https://www.facebook.com/mongolmilk.mn/> фэйсбүүк хуудсаар дамжуулан, олон нийтэд нээлттэй явууллаа.

Хурлын цаг: 15:00-17:00,

Хурлын байршил: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, “Холидэй Инн” зочид буудлын байранд, Цахим хэлбэрээр,

Хурлын дарга: Ц.Соёл-Эрдэнэ,

Хурлын нарийн бичгийн дарга: Б.Цэрэндорж,

Хурлын ирц: Саналын эрх бүхий 319,081,765 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 93.1%,

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай асуудал,
3. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудал,
4. “Сүү” ХК-ийн охин компани болох “Макс Агро” ХХК-ийг “Сүү” ХК-тай нэгтгэх тухай асуудал,
5. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал,
6. “Сүү” ХК-ийн 2019 оны ногдол ашиг тараалтын тайлан болон 2020 оны цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх,

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай асуудал,
3. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудал,
4. “Сүү” ХК-ийн охин компани болох “Макс Агро” ХХК-ийг “Сүү” ХК-тай нэгтгэх тухай асуудал,
5. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал,
6. “Сүү” ХК-ийн 2019 оны ногдол ашиг тараалтын тайлан болон 2020 оны цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх,

Танилцуулсан нь:

Нарийн бичгийн дарга:

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. “Сүү” ХК-ийн 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлж байна.

Та бүхэнд “Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын гаргасан, Хурлын ирцийн тухай тогтоолыг танилцуулъя.

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2021 оны 04-р сарын 30-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

ХУРЛЫН ИРЦИЙН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, “Сүү” Хувьцаат компанийн дүрмийн 5.4-т заасныг тус тус үндэслэн, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссоос ТОГТООХ НЬ:

1. 2021 оны 04 дүгээр сарын 09-ны өдрөөр тогтоосон “Сүү” ХК-ийн 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийн байдлаар компанийн гаргасан нийт 344,000,000 ширхэг хувьцаанаас 1,266,391 ширхэг халаасны хувьцааг хасч, тус хуралд саналын эрх бүхий 342,733,609 ширхэг хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцож санал өгөх эрхтэй болохыг дурдсугай.

2. Тус хуралд оролцох саналын эрх бүхий 342,733,609 ширхэг хувьцааны 93.1% буюу 319,081,765 ширхэг хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд хүрэлцэн ирсэн буюу хуралд оролцож байгааг Хурлын даргад мэдээлсүгэй.

3. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт зааснаар “Сүү” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг тогтоосугай.

Тооллогын комиссын
Тооллогын комиссын

дарга: / /

Гишүүд: / /

Та бүхэнд “Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг танилцуулъя.

- Хурлын Нарийн бичгийн дарга хуралдааны дэгийг танилцуулав.

Хурлыг нээж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга, “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Ц.Соёл-Эрдэнэ үг хэлнэ.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга:

Хурлыг нээж үг хэлэв.

Нарийн бичгийн дарга:

Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргад баярлалаа. Одоо дэгийн дагуу хэлэлцэх эхний асуудал болох Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал байгаа. Холбогдох танилцуулгыг Гүйцэтгэх захирал М.Болод танилцуулах байгаа.

- “Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал М.Болод Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалтай холбогдох танилцуулгыг хийв.

Нарийн бичгийн дарга:

Одоо дэгийн дагуу хэлэлцэх дараагийн асуудал болох ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай асуудал байгаа.

Та бүхэнд өнөөдрийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа буюу бүрэн эрх нь дуусгавар болж байгаа ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ердийн гишүүнээр:

1. Д.Ганбаатар
2. Д.Цэрэнжигмэд
3. Б.Түвшинтөгс
4. Д.Жамъян
5. Д.Уянгалянхуа
6. Ц.Соёл-Эрдэнэ
7. Д.Тунгалаг
8. С.Сүхболд

Хараат бус гишүүнээр:

1. Н.Цэрэндорж
2. Ш.Даваалимбэ
3. Г.Баяр
4. П.Мэндсайхан

Та бүхэнд “Сүү” ХК-ийн ТУЗ-д улиран сонгогдохоор нэр дэвшиж буй гишүүдийг танилцуулъя.

Ердийн гишүүнээр:

1. Д.Ганбаатар
2. Д.Цэрэнжигмэд
3. Б.Түвшинтөгс
4. Д.Жамъян
5. Д.Уянгалянхуа
6. Ц.Соёл-Эрдэнэ
7. Д.Тунгалаг
8. С.Сүхболд

Хараат бус гишүүнээр:

5. Н.Цэрэндорж
6. Ш.Даваалимбэ
7. Г.Баяр
8. П.Мэндсайхан

ТУЗ-д нэр дэвшиж буй гишүүдийн дэлгэрэнгүй танилцуулгыг дэлгэцээр танилцуулав.

Нарийн бичгийн дарга:

Дэгийн дагуу хэлэлцэх дараагийн асуудал болох ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудал байгаа.

“Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооноос Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгох цалин, урамшууллын төсвийг дараах байдлаар тогтоож, төсөвт нийцүүлэн цалин, урамшууллыг олгох зохицуулалтыг “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журам”-д нарийвчлан тусгахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгаж, 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцон олгох санал гаргасан байгаа. Үүнд:

№	Албан тушаал	Тухайн жилд олгох цалин, урамшууллын нийт хэмжээ
1.	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга болон гишүүд	Компанийн жилийн цалингийн зардлын төлөвлөгөөний 2.8%

Нарийн бичгийн дарга:

Дэгийн дагуу хэлэлцэх дараагийн асуудал болох “Сүү” ХК-ийн охин компани болох “Макс Агро” ХХК-ийг “Сүү” ХК-тай нэгтгэх тухай асуудал байгаа.

- Хурлын Нарийн бичгийн дарга “Сүү” ХК-ийн охин компани болох “Макс Агро” ХХК-ийг “Сүү” ХК-тай нэгтгэх тухай асуудалтай холбогдох танилцуулгыг танилцуулав.

Нарийн бичгийн дарга:

Дэгийн дагуу хэлэлцэх дараагийн асуудал болох Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал байгаа.

Та бүхэнд “Сүү” ХК-ийн дүрэм оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтийн төслийг танилцуулъя. Үүнд:

№	Одоогийн заалт	Нэмэлт өөрчлөлт орсны дараа
1.	3.2. Компани нь сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, сүүний тээврийн үйлчилгээ болон бусад хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа явуулна.	3.2. Компани нь сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, сүүний тээврийн үйлчилгээ болон сүүний үхрийн фермерийн аж ахуй, малын тэжээлийн ургамал, хүнсний ногоо тариалах, бусад хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа явуулна.

Нарийн бичгийн дарга: Дараагийн танилцуулах асуудал болох “Сүү” ХК-ийн 2019 оны ногдол ашиг тараалтын тайлан болон 2020 оны цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх та бүхэнд танилцуулъя.

- Хурлын “Сүү” ХК-ийн 2019 оны ногдол ашиг тараалтын тайлан болон 2020 оны цэвэр ашгаас ногдол ашиг тараах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг танилцуулав.

Одоо дэгийн дагуу хурал 10 минут завсарлана. Энэ хугацаанд та бүхэн хэлэлцсэн асуудлуудтай холбоотой асуулт болон саналаа энэхүү цахим хурал явагдаж байгаа компанийн албан ёсны фэйсбүүк хуудсанд мессеж бичих, эсвэл компанийн албан ёсны имэйл хаяг болох info@mongolmilk.mn цахим шуудангаар илгээж болно. Хурлын завсарлага дууссаны дараа Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал, асуултуудад хариулт өгөх болно.

Хурал завсарлав.

Нарийн бичгийн дарга: Дэгийн дагуу Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултуудад хариулах хугацаа эхэлж байна. Та бүхэнд Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултуудыг уншиж танилцуулъя.

- Хувьцаа бэлэглэх талаар ярьлаа. Ямар хүмүүст олгох вэ?
- 2021 оны борлуулалтын төлөвлөгөөг өмнөх оноос 30 гаруй хувиар нэмэгдүүлэх талаар ярилаа. Зах зээлийн хувьд ийм хэмжээний өсөлт гаргах боломж байгаа юу?
- Ковид-19 халдвар нэмэгдэж, он гарснаас хойш олон удаа хөл хорио тавигдлаа. Энэ нөхцөл байдал танай бизнест, орлогод хэр нөлөөлж байна вэ?
- Компани энэ онд цэвэр ашгийнхаа 40%-ийг ногдол ашигт тараахаар шийдвэрлэсэн байна. Цаашид ногдол ашгийн хувь хэмжээн дээр ямар бодлого баримталж байгаа вэ?
- “Нэмэлт хувьцаа гаргах” асуудал яригдаж байсан. Энэ асуудал юу болсон бэ?

Гүйцэтгэх захирал М.Болод:

- Хувьцаа бэлэглэх талаар ярьлаа. Ямар хүмүүст олгох вэ?
 - Танилцуулгад мэдээллийг дэлгэрэнгүй тусгасан байгаа. Компанийн зүгээс хувьцааны төвлөрлийг бууруулж, хөрөнгө оруулагчдын идэвх, сонирхлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлуудыг хийж байгаа. Энэ ажлын хүрээнд “Хувьцаажуулах хөтөлбөр”-ийг зохион байгуулж байгаа. Эхний үе шат болгож сүүгээ тогтвортой нийлүүлж байгаа 1100 гаруй бэлтгэн нийлүүлэгч, 470 ажилтан, 3700 харилцагчдаа “Сүү” ХК-ийн нийт 1,2 сая ширхэг хувьцааг энэ ондоо бэлэг болон урамшуулал хэлбэрээр олгоно.
- 2021 оны борлуулалтын төлөвлөгөөг өмнөх оноос 30 гаруй хувиар нэмэгдүүлэх талаар ярилаа. Зах зээлийн хувьд ийм хэмжээний өсөлт гаргах боломж байгаа юу?
 - Дархлаа дэмжих бүтээгдэхүүн гэдэг утгаараа сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ 15% өссөн байгаа. Сүү бол стратегийн 4 гол бүтээгдэхүүний нэг. Зөвхөн цай сүлдэг бүтээгдэхүүн биш бөгөөд эрүүл мэндийн чухал ач холбогдолтой байдаг. Энэ талын ойлголт хэрэглэгч дунд нэмэгдэж байна. Сүү, сүүн бүтээгдэхүүн бага хүрч байгаа орон нутгийн борлуулалт болон зайрмаг, уураглаг цагаан идээний борлуулалт дээрээ анхаарч, 30%-ийн борлуулалтын өсөлт хийхээр ажиллана.
- Ковид-19 халдвар нэмэгдэж, он гарснаас хойш олон удаа хөл хорио тавигдлаа. Энэ нөхцөл байдал танай бизнест, орлогод хэр нөлөөлж байна вэ?
 - Хөл хорионы улмаас гэр бүлийн хэрэглээний зориулалттай бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэж байна. Борлуулалтын төлөвлөгөө 45%-иар давж биелэсэн, мөн 2020 оны борлуулалттай харьцуулахад 2 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

ТУЗ-ийн дарга Д.Ганбаатар:

- Компани энэ онд цэвэр ашгийн 40%-ийг ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн байна. Цаашид ногдол ашиг тараалтын хувь хэмжээн дээр ямар бодлого баримталж байгаа вэ?
 - Компани 2016 оноос хойш тасралтгүй ногдол ашиг тарааж байгаа. Энэ хугацаанд нийт 10 орчим тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилсан байна. Цаашид ногдол ашиг тогтвортой хуваарилах, хөрөнгө оруулагчдын хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогоо үргэлжлүүлэн ажиллаж, энэ онд тараасан ногдол ашгийн хэмжээгээ ирэх онд 2 дахин нэмэгдүүлэхээр ажиллана.
- “Нэмэлт хувьцаа гаргах” асуудал яригдаж байсан. Энэ асуудал юу болсон бэ?
 - Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, ковидын нөлөөллөөс шалтгаалж, зарим хэлцлүүдийг хойшлуулах шаардлага тулгарсан учраас нэмэлт хувьцаа гаргах ажлыг тодорхойгүй хойшлуулсан байгаа. Цаг үеийн байдал сайжирсны дараа дахин энэ асуудлыг авч хэлэлцэхээр төлөвлөж байна. Цаашид магадгүй компанийнхаа 50% хүртэлх хэмжээний хувьцааг олон нийтэд гаргах зорилго байгаа.

Нарийн бичгийн дарга: Асуулт хариултад хариулах үе дууслаа. Одоо дэгийн дагуу хурлаар хэлэлцсэн асуудлуудаар хувьцаа эзэмшигчдээс цахим хэлбэрээр санал хураалт явуулах ёстой байгаа. Та бүхэнд саналын хуудасны загвар болон санал хэрхэн өгөх зааварчилгааг цахимаар танилцуулсан байгаа. Одоо дэгийн дагуу хурал завсарлана. Завсарлагааны дараа Тооллогын комиссын тогтоолыг Тооллогын комиссын дарга Т.Дамдинсүрэн танилцуулна.

Хурал завсарлав.

Тооллогын комиссын дарга: Тооллогын комисс хэлэлцэх асуудлуудтай холбоотойгоор Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураалтаар хэлэлцсэн асуудал тус бүр дээр гарсан саналын дүнг нэгтгэн, тогтоол гаргасан байгааг та бүхэнд уншиж танилцуулъя.

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2021 оны 04-р сарын 30-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

САНАЛ ХУРААЛТЫН НЭГДСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсэг, “Сүү” ХК-ийн 2021 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д санал хураалтаар хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураах хуудсыг тоолсон тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон саналын эрхтэй нийт 319,081,765 ширхэг хувьцааны 99.99% буюу 319,074,060 ширхэг хувьцаа эзэмшиж буй 17 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар саналаа ирүүлснээс 319,074,060 ширхэг хувьцаа эзэмшиж буй 17 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүчин төгөлдөрт тооцсугай.

2. Ердийн журмаар санал өгөх хувьцааны тоог 319,074,060 ширхэгээр тогтоосугай.

3. Саналын хуудсаар “Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 100 % зөвшөөрсөн, - % татгалзсан, - % түтгэлзсэн байгааг мэдэгдсүгэй.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
319,074,060	100%	-	-%	-	-%

4. Саналын хуудсаар “ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, - % татгалзсан, - % түтгэлзсэн байгааг мэдэгдсүгэй.

№	Батлагдсан тогтоолууд		Зөвшөөрсөн хувьцааны санал		Татгалзсан хувьцааны санал	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
1.	ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ ЧӨЛӨӨЛЖ, ТОМИЛОХ ТУХАЙ	Ердийн гишүүнээр:				
		1. Д.Ганбаатар	319,076,102	8.33%		
		2. Д.Цэрэнжигмэд	319,073,791	8.33%		
		3. Д.Жамъян	319,073,791	8.33%		

4. Ц.Соёл-Эрдэнэ	319,074,220	8.33%		
5. Б.Түвшинтөгс	319,073,790	8.33%		
6. Д.Уянгалянхуа	319,073,790	8.33%		
7. Д.Тунгалаг	319,073,790	8.33%		
8. С.Сүхболд	319,073,790	8.33%		
Хараат бус гишүүнээр:				
9. Н.Цэрэндорж	319,074,784	8.33%		
10. Г.Баяр	319,073,804	8.33%		
11. Ш.Даваалимбэ	319,073,784	8.33%		
12. П.Мэндсайхан	319,073,284	8.33%		

5. Саналын хуудсаар “ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99 % зөвшөөрсөн, - % татгалзсан, 0.00003% түтгэлзсэн байгааг мэдэгдсүгэй.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
319,073,961	99.99%	-	-%	99	0.00003%

6. Саналын хуудсаар “Сүү” ХК-ийн охин компани болох “Макс Агро” ХХК-ийг “Сүү” ХК-тай нэгтгэх тухай” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 0.0003 % зөвшөөрсөн, 99.99% татгалзсан, - % түтгэлзсэн байгааг мэдэгдсүгэй.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
1000	0.0003%	319,073,060	99.99%	-	- %

7. Саналын хуудсаар “Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 100 % зөвшөөрсөн, - % татгалзсан, - % түтгэлзсэн байгааг мэдэгдсүгэй.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
319,074,060	100%	-	- %	-	- %

Тооллогын комиссын

дарга: / /

Гишүүд: / /

Нарийн бичгийн дарга: Одоо дэгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга “Сүү” ХК-ийн 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан тогтоолуудыг уншиж танилцуулна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолуудыг уншиж танилцуулан хурал 17:00 цагт хаасныг мэдэгдэв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Хянасан:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА:



/Б.ЦЭРЭНДОРЖ/

/Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ/